



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26 21 35,
Факс: (976-11) 32 21 27, И-мэйл: info@mfa.gov.mn,
Вэбсайт: www.mfa.gov.mn

2020.04.23

№ 09/1980

танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

“Дипломат болон албан/сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Грек Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Нью-Йорк хотноо 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурсан.

Уг хэлэлцээр түүний 11 дүгээр зүйлд “Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн бичгэн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно” гэж заасны дагуу уг хэлэлцээр 2020 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болохыг үүгээр мэдэгдэв.

Холбогдох байгууллагадаа уламжилна уу.

Хавсралт: Хэлэлцээрийн хуулбар

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Д.ДАВААСҮРЭН

*Шүтээн зориулалттай
Батаарх, Нармагдарах
нарт танилцуулж
орлон гутаах илрэн
ОН ажиллах*

Д.Д. 14/45

081524



**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН/СЕРВИС ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ГРЕК УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Оршил

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Грек Улсын Засгийн газар, цаашид "Хэлэлцэн тохиролцогч талууд" гэх:

Хоёр талын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэж, хоёр улс хоорондын найрамдалт харилцааг улам бэхжүүлэх нь тэдгээрийн ашиг сонирхол гэж үзэж, аль нэг талын дипломат болон албан/сервис паспорт эзэмшигч иргэд нөгөө талын нутаг дэвсгэрт зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зорилгоор

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр нь дараахь ангилал бүхий паспортын хувьд үйлчилнэ.

- Монгол Улсын хувьд: хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт
- Бүгд Найрамдах Грек Улсын хувьд: хүчин төгөлдөр дипломат болон сервис паспорт

2 дугаар зүйл

(1) Хүчинтэй монгол дипломат болон албан паспорт эзэмшигч Монгол Улсын иргэд Европын Холбооны хууль тогтоомжийн болон түүний суурь баримт бичгийн салшгүй хэсэг болох Шенгений хэлэлцээрт гарын үсэг зурсан аль нэг улсын нутаг дэвсгэрт анх нэвтрэн орсон өдрөөс эхлэн зуун ная (180) хоногийн хугацаанд ер (90) хүртэлх хоног (хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь) Бүгд Найрамдах Грек Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, зорчиход визийн шаардлагаас чөлөөлөгдөнө.

(2) Хүчинтэй грек дипломат болон сервис паспорт эзэмшигч Грек Улсын иргэд зуун ная (180) хоногийн хугацаанд ер (90) хүртэлх хоног (хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь) Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх, дамжин өнгөрөх, зорчиход визийн шаардлагаас чөлөөлөгдөнө.

(3) Хэлэлцэн тохиролцогч талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл шаардагдах ашгийн төлөө /цалинтай/ үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байрлах Олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газар, Дипломат төлөөлөгчийн газар болон Консулын төлөөлөгчийн газарт томилогдсон бөгөөд энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд тодорхойлсон паспорт эзэмшигч Хэлэлцэн тохиролцогч талын иргэн Хүлээн авагч улсад ирэхээсээ өмнө зөвшөөрлийн (аккредитаци) виз авах үүрэгтэй.

(2) Энэхүү хэлэлцээрийн дагуу энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан этгээдийн мөн хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан паспорт эзэмшигч иргэний гэр бүлийн гишүүн Хүлээн авагч улсад ирэхээсээ өмнө виз авах үүрэгтэй.

(3) Хүлээн авагч улс өөрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу энэхүү зүйлийн 1 болон 2 дэх хэсэгт дурдсан этгээдэд виз олгоно.

4 дүгээр зүйл

(1) Европын Холбооны хилээр зөвхөн хилийн боомтоор дамжин нэвтэрнэ.

(2) Талууд өөрсдийн хилийн боомтын жагсаалтыг харилцан мэдэгдэнэ.

5 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн 2 болон 3 дугаар зүйлд дурдсан этгээдийн Хүлээн авагч улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүргийг энэхүү хэлэлцээрээр хөндөхгүй. Европын холбооны гишүүн улсын, эсхүл бусад олон улсын гэрээгээр хүлээсэн талуудын эрх, үүрэгт энэхүү хэлэлцээр нөлөөлөхгүй.

6 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр тааламжгүй гэж үзсэн, эсхүл түүний нутаг дэвсгэрт оршин суух болон нэвтрэхтэй холбоотой хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэнийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэхээс татгалзах, эсхүл зорчихыг хориглох Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эрх бүхий байгууллагын бүрэн эрхийг хөндөхгүй

7 дугаар зүйл

- (1) Энэхүү хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс 30 хоногийн дотор хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан паспортын загварыг дипломат шугамаар харилцан солилцоно.
- (2) Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан паспортад өөрчлөлт оруулах тохиолдолд эдгээр зорчих бичиг баримтын загварыг дипломат шугамаар нэн даруй Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд хүргүүлнэ. Хэлэлцэн тохиролцогч талууд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжийн дагуу машинаар уншигдах зорчих бичиг баримтын стандартыг хэрэглэнэ.
- (3) Хэлэлцэн тохиролцогч талууд 1 дүгээр зүйлд дурдсан паспорт олгохтой холбоотой дотоодын хууль тогтоомжид оруулсан аливаа өөрчлөлтийг нэн даруй харилцан мэдэгдэнэ.
- (4) Эдгээр паспортыг хүчингүй болгосон, үрэгдүүлсэн, хулгайд алдсан тохиолдолд Хэлэлцэн тохиролцогч талууд дипломат шугамаар нэн даруй харилцан мэдэгдэнэ.

8 дугаар зүйл

- (1) Хэлэлцэн тохиролцогч тал үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам болон олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр зогсоох эрхтэй.
- (2) Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоох болсноо Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд түүнийг хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс 15 хоногийн дотор дипломат шугамаар мэдэгдэнэ.
- (3) Энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоох шийдвэр нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэн орсон энэхүү хэлэлцээрийн 2 болон 3 дугаар зүйлд дурдсан Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэний эрхийг хөндөхгүй.
- (4) Энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоосон Хэлэлцэн тохиролцогч тал уг шийдвэрийг хүчингүй болгох тухайгаа түүнийг хүчин төгөлдөр мөрдөгдөж

эхлэхээс далан хоёр (72) цагийн дотор Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах буюу хэрэглэхтэй холбротой аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч талууд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрт Хэлэлцэн тохиролцогч талууд зөвшилцөх замаар бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аливаа нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд дурдсан журмын дагуу хүчин төгөлдөр болно.


11 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн бичгэн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү хэлэлцээрийг хугацаагүй байгуулав. Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал дипломат шугамаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэх замаар хэлэлцээрийг аль ч үед цуцалж болно.

Мюнхен хотноо 2020 оны 2 дугаар сарын 14-ны өдөр монгол, грек, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**



Гадаад харилцааны сайд
Дамдины Цогтбаатар

**БҮГД НАЙРАМДАХ ГРЕК УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**



Гадаад хэргийн сайд
Николаос-Георгиос С.Дэндиас



**AGREEMENT
BETWEEN
THE GOVERNMENT OF MONGOLIA
AND
THE GOVERNMENT OF THE HELLENIC REPUBLIC
ON
VISA WAIVER
FOR HOLDERS OF DIPLOMATIC AND SERVICE/OFFICIAL PASSPORTS**

Preamble

The Government of Mongolia and the Government of the Hellenic Republic hereinafter referred to as "the Parties",

Desiring to expand their bilateral relations, considering their interest in strengthening their existing friendly relations and with a view to facilitating travel of nationals of the one Party, holders of valid diplomatic and service/official passports, to the territory of the other Party,

Have agreed as follows:

Article 1

This Agreement shall apply to the following categories of passports:

- For Mongolia: valid diplomatic and official passports
- For the Hellenic Republic: valid diplomatic and service passports

Article 2

- (1) Mongolian nationals holding valid Mongolian diplomatic and official passports, shall be exempt from visa requirements to enter and stay in the territory of the Hellenic Republic for up to ninety (90) days (in one or several periods), in any one hundred and eighty (180) day period following the date of the first entry into the territory of one of the signatories to the Schengen Agreement, which forms part of the Schengen acquis integrated into the framework of the European Union and the provisions of EU law that constitute its development.
- (2) Greek nationals holding valid Greek diplomatic and service passports shall be exempt from visa requirements to enter, transit through, stay in and leave the territory of Mongolia for up to ninety (90) days (in one or several periods) in any one hundred and eighty (180)-day period.
- (3) The exercise of paid activities, for which a work permit is required under the national legislation of the Parties, is not permitted.

Article 3

- (1) This Agreement does not exempt nationals of either Party, holders of passports defined in Article 1, who are appointed to the diplomatic mission or consular posts of that Party to the territory of the other Party or are representatives of that Party to international organizations having their seat in the territory of the other Party from the requirement to obtain a visa for accreditation by the receiving State prior to their arrival at its territory.
- (2) This Agreement does not exempt the family members of the persons mentioned in paragraph 1, who form part of their household and are holders of passports defined in Article 1, from the requirement to obtain a visa by the receiving State prior to their arrival at its territory.
- (3) The receiving State shall issue the visas mentioned in paragraphs 1 and 2 in accordance with its national legislation.

Article 4

- (1) External borders may be crossed only at border crossing points.
- (2) The Parties shall notify the list of their border crossing points to each other.

Article 5

This Agreement shall not affect the obligation of the individuals mentioned in Articles 2 and 3 of this Agreement to respect the laws of the receiving State. The present Agreement does not affect rights and obligations of the Parties arising from

their participation to other international agreements or from their membership to the European Union.

Article 6

This Agreement shall not affect the right of the competent authorities of either Party to refuse entry or prohibit the stay to those persons declared undesirable or who fail to meet the conditions in force for entry and residence in the territory of their States.

Article 7

(1) The Parties shall exchange specimens of their passports mentioned in Article 1 through diplomatic channels within thirty (30) days after the date of receipt of the last written notification by which the Parties inform each other, through diplomatic channels, about the completion of their relevant internal procedures for the entry into force of the Agreement in accordance with the procedure described in Article 11.

(2) If a Party modifies its existing passports mentioned in Article 1, it shall provide the other Party, without delay through diplomatic channels, with specimens of these travel documents. The Parties shall apply the standards for machine-readable travel documents recommended by the International Civil Aviation Organization (ICAO).

(3) The Parties shall notify each other without delay of any changes in the national legislation regarding the issuance of the passports mentioned in Article 1.

(4) In the case of loss, theft or invalidation of these passports, the Parties shall notify each other without delay, through diplomatic channels.

Article 8

(1) Either Party may suspend, either in whole or in part, the implementation of this Agreement for reasons of national security, public order or public health.

(2) The other Party shall be notified in writing of the suspension of the implementation of this Agreement through diplomatic channels, no later than 15 calendar days prior to the entry into effect of such measure.

(3) The suspension of the implementation of this Agreement shall not affect the rights of nationals of either Party mentioned in Articles 2 and 3 of this Agreement already present in the territory of the State of the other Party.

(4) The Party that has suspended the implementation of this Agreement shall notify the other Party in writing through diplomatic channels of the revocation of the suspension of the implementation of this Agreement, no later than seventy-two (72) hours prior to the entry into effect of such measure.

Article 9

Any differences regarding the interpretation or the application of this Agreement shall be settled between the Parties through diplomatic channels.

Article 10

This Agreement may be amended by the written consent of the Parties. Any such amendments shall enter into force in accordance with the procedure provided for in Article 11 for the entry into force of this Agreement.

Article 11

This Agreement shall enter into force 30 days after the date of receipt of the last written notification by which the Parties inform each other, through diplomatic channels, about the completion of their relevant internal procedures.

It shall remain in force for an indefinite period of time. Either Party may terminate it at any time by sending a thirty (30)-day prior written notification to the other Party through diplomatic channels.


Done in Munich, on February ¹⁴ 2020, in two originals, each in the Mongolian, Greek and English languages, all texts being equally authentic. In case of divergence in the interpretation the English text shall prevail.

**FOR THE GOVERNMENT OF
MONGOLIA**



.....
H.E. Mr Damdin Tsogtbaatar
Minister for Foreign Affairs

**FOR THE GOVERNMENT OF
THE HELLENIC REPUBLIC**



.....
H.E. Mr Nikolaos-Georgios S.Dendias
Minister for Foreign Affairs